



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 08 сарын 09 өдөр

Дугаар А/308

Сүхбаатар сум

Захиргааны хэм хэмжээний актын талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", "л", 30 дугаар зүйлийн 30.1.9, Захиргааны ерөнхий хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны 28 дугаар тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хууль тогтоомжтой давхардсан, ач холбогдлоо алдан дагаж мөрдөх шаардлагагүй болсон, нэмэлт, өөрчлөлт оруулсан буюу хөдөлгөөн хийгдээгүй, хүчингүй болсон захиргааны хэм хэмжээний актын судалгаагаа 2018 оны 11 дүгээр сард багтаан аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэст ирүүлж, хуулиар тусгайлан эрх олгогдсон боловч батлаагүй, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхгүйгээр дагаж мөрдөж байгаа шийдвэрүүдээ хянан үзэж, шаардлагатай тохиолдолд тэдгээрийг батлах, бүртгүүлэх ажлыг 2018 онд багтаан зохион байгуулж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг захиргааны байгууллагуудын дарга нарт үүрэг болгосугай.

2.Захиргааны байгууллагуудын хуулиар тусгайлан эрх олгогдсон заалтын хүрээнд гаргах шаардлагатай захиргааны хэм хэмжээний актуудыг гаргуулах, ач холбогдлоо алдаж дагаж мөрдөх шаардлагагүй болсон, хууль тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн шийдвэрүүдийг хүчингүй болгож, хуульд нийцүүлэх, улсын нэгдсэн санд бүртгэлтэй шийдвэрүүдийг хянан үзэж, цэгцлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга /Д.Ёндонжамц/-д даалгасугай.

3.Захиргааны ерөнхий хуулийг үйл ажиллагаандаа дагаж мөрдөн хэвшүүлэх, цаашид уг хуультай холбоотой зөрчил гаргахгүй байх, гаргасан тохиолдолд хариуцлага тооцож ажиллахыг нийт сумдын Засаг дарга, агентлагийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ш.ОРГИЛ